



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 6/93

Хэрлэн сум

Г Н.Эрдэнэсүхийг ажилд томилох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.2.2, 9.2.3 дахь заалт, Засгийн газрын 1999 оны Цэргийн цолны цалингийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай 38 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай 472 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2004 оны Зэвсэгт хүчиний офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам батлах тухай 123 дугаар тогтоол, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 9 дүгээр сарын 14-ний Б/335 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нарантунгалагийн Эрдэнэсүхийг Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалт эрхэлсэн офицeroор 2022 оны 9 дүгээр сарын 15-аас эхлэн томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Н.Хүрэлзээ

Цэргийн штабын дарга

Гишүүд:

Л.Цэнддорж

Цэргийн штабын Дайчилгааны
офицер

Т.Баяртуяа

Нярав

3. Н.Эрдэнэсүхийн цалинг ТТ-13-4 шатлалаар тогтоон үндсэн цалин 901,798 (есөн зуун нэг мянга долоон зуун ерэн найман) төгрөгөөр, цэргийн цолны цалинг 32 хувь, удаан жил ажилласны нэмэгдлийг 12 хувь, онцгой нөхцөлийн нэмэгдлийг 10 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4. Н.Эрдэнэсүхэд томилогдоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Ж.Гантулга)-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР

